



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Шинэ Ховд Жаргалант ТҮК” (Эрч хүч тохижилт үйлчилгээ ОНӨХХК)-ны
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/011/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Д.Нямгарав Утас: 70432545 Цахим хаяг: nyamgaravd@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	5
3.1 Төлбөрийн акт	5
3.2 Албан шаардлага	6
3.3 Зөвлөмж	6
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	8
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

ААДБ.03.30 № 283
танай _____ -ны № _____ -т

“ЭРЧ ХҮЧ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ”
ОНӨХХК-НИЙ ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ Ховд Жаргалант ТҮК” (“Эрч хүч тохижилт үйлчилгээ”ОНӨХХК)-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас “Шинэ Ховд Жаргалант ТҮК” (“Эрч хүч тохижилт үйлчилгээ” ОНӨХХК)-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтот түвшний гүйцэтгэлд дүгнэлт өгөхгүй.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 8 дугаар зүйлийн 8.9.8, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 10 дугаар зүйлийн 10.2, 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 16 дугаар зүйлийн 16.1.4, Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал”-ийн 6.3 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Байгууллагын нягтлан бодогч нь тайлант хугацааны байгууллагад хөтлөх анхан шатны баримтыг бүрэн хөтлөөгүй, 292.3 сая төгрөгийн шатахууны тооцоонд дангаараа хяналт хэрэгжүүлэн зарцуулсан байж болзошгүй,
- Байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд няравын бараа материалын тооцоо бодоогүй, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлээгүй, 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 145.9 сая төгрөгийн бараа материалыг тэг

A4 Албан тоот

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,854,007.35	218,156,491.31
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,992,318.35	20,712,047.91
31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	1,992,318.35	20,712,047.91
31210	1.1.1.02.01 Төгрөг	1,992,318.35	20,712,047.91
31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	1,992,318.35	20,712,047.91
33	1.1.3 АВЛАГА	19,157,939.00	50,654,893.00
33500	1.1.3.07 Бусад авлага	19,157,939.00	50,654,893.00
33510	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	19,157,939.00	50,654,893.00
34	1.1.4 УРЬДЧИЛГАА	2,790,000.00	870,000.00
34600	1.1.4.06 Урьдчилж гарсан зардал	2,790,000.00	870,000.00
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	87,913,750.00	145,919,550.40
35400	1.1.5.04 Хангамжийн материал	87,913,750.00	145,919,550.40
35410	1.1.5.04.01 Бичиг хэргийн материал	-	360,000.00
35420	1.1.5.04.02 Аж ахуйн материал	3,896,750.00	6,699,450.40
35430	1.1.5.04.03 Сэлбэг хэрэгсэл	-	53,116,500.00
35470	1.1.5.04.07 Бусад хангамжийн материал	84,017,000.00	85,743,600.00
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	829,328,280.88	1,847,427,330.56
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	829,328,280.88	1,847,427,330.56
39200	1.2.2.02 Биет хөрөнгө	828,859,530.99	1,847,271,080.71
39201	1.2.2.02.01 Барилга, байгууламж, орон сууц	-	110,750,987.00
39202	1.2.2.02.02 Хуримтлагдсан элэгдэл	-	(3,691,699.56)
39203	1.2.2.02.03 Авто-тээврийн хэрэгсэл	774,129,900.00	1,767,501,436.00
39204	1.2.2.02.04 Хуримтлагдсан элэгдэл	(367,698,576.71)	(502,299,509.53)
39205	1.2.2.02.05 Машин тоног төхөөрөмж(компьютер)	25,754,899.00	25,754,899.00
39206	1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл	(5,563,037.57)	(10,831,714.12)
39207	1.2.2.02.07 Тавилга, аж ахуйн эд хогшил	437,316,605.00	600,105,295.56
39208	1.2.2.02.08 Хуримтлагдсан элэгдэл	(59,725,862.34)	(143,020,928.64)
39214	1.2.2.02.14 Бусад үндсэн хөрөнгө	136,585,600.00	136,585,600.00
39215	1.2.2.02.15 Хуримтлагдсан элэгдэл	(111,939,996.39)	(133,583,285.00)
39300	1.2.2.03 Биет бус хөрөнгө	468,749.89	156,249.85
39301	1.2.2.03.01 Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	1.2.2.03.02 Хуримтлагдсан элэгдэл	(781,250.11)	(1,093,750.15)
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	941,182,288.23	2,065,583,821.87
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	62,496,224.34	352,258,472.12
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	62,496,224.34	352,258,472.12
41300	2.1.1.03 Өглөг	62,496,224.34	352,258,472.12
41360	2.1.1.03.06 Бусад өглөг	62,496,224.34	352,258,472.12
41361	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	-	96,292,046.00
41363	2.1.1.03.06.03 Татварын өглөг /ТӨҮГ/	62,496,224.34	137,600,916.36
41364	2.1.1.03.06.04 НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	118,365,509.76
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	878,686,063.89	1,713,325,349.75
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	878,686,063.89	1,713,325,349.75
51101	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/	20,000.00	20,000.00
51106	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	519,581,465.00	519,581,465.00
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	359,084,598.89	1,193,723,884.75
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	352,132,398.12	1,622,445,812.45
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	6,952,200.77	(428,721,927.70)
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	941,182,288.23	2,065,583,821.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	169,757,870.50	(179,909,763.82)
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	169,757,870.50	(179,909,763.82)
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	169,757,870.50	(179,909,763.82)
120010	1.1.1.04.1.10 Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	2,168,909,700.00	1,879,495,945.51
120011	1.1.1.04.1.11 Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	1,999,151,829.50	2,059,405,709.33
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	162,805,669.73	248,812,163.88
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	162,805,669.73	248,812,163.88
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	162,805,669.73	248,812,163.88
2109	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	162,805,669.73	248,812,163.88
210903	1.1.2.01.1.09.03 Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	162,805,669.73	248,812,163.88
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,952,200.77	(428,721,927.70)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	6,952,200.77	(428,721,927.70)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,601,465.0	352,132,398.1	871,733,863.1
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	519,601,465.0	352,132,398.1	871,733,863.1
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-	6,952,200.8	6,952,200.8
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,601,465.0	359,084,598.9	878,686,063.9
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	519,601,465.0	359,084,598.9	878,686,063.9
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	519,601,465.0	359,084,598.9	878,686,063.9
16	1.4 Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	1,263,361,213.6	1,263,361,213.6
19	1.7 Тайлант үеийн үр дүн	-	(428,721,927.7)	(428,721,927.7)
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	519,601,465.0	1,193,723,884.8	1,713,325,349.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,953,541,700.0	1,879,495,945.5
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,953,541,700.0	1,879,495,945.5
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,953,541,700.0	1,879,495,945.5
120013	1.1.1.1.04.1.10 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,953,541,700.0	1,879,495,945.5
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,951,755,180.3	1,860,776,216.0
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,951,755,180.3	1,860,776,216.0
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,951,755,180.3	1,860,776,216.0
2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,014,404,702.7	908,101,539.0
210106	1.1.1.2.01.1.01.06 Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	1,014,404,702.7	908,101,539.0
2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,323,437.9	-
210206	1.1.1.2.01.1.02.06 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	115,323,437.9	-
2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	529,561,754.0	476,880,798.0
210409	1.1.1.2.01.1.04.07 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	239,889,508.0	-

210410	1.1.1.2.01.1.04.08	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	289,672,246.0	476,880,798.0
2108	1.1.1.2.01.1.08	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	292,465,285.6	475,793,879.0
210816	1.1.1.2.01.1.08.11	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	56,389,406.6
210817	1.1.1.2.01.1.08.12	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	160,500,000.0
210818	1.1.1.2.01.1.08.13	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	292,465,285.6	258,904,472.3
III	1.1.1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,786,519.7	18,719,729.6
VIII	1.1	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,786,519.7	18,719,729.6
101	1.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	205,798.6	1,992,318.4
20	1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,992,318.4	20,712,047.9

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 682,443.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 110,750.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2025.07.18-ний өдрийн А/54 тоот тогтоолоор Бичигт багийн халуун усны барилгыг Шим ус ОНӨААТҮГ-аас шилжүүлэн авсныг үндсэн хөрөнгөнд тусгаагүй,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 571,692.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын 16,211.3 мянган төгрөгийн түвшнээс “их”, санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байгаа тул “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 571,692.4 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс, 4,062.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 543,233.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 24,391.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2025 онд тус байгууллагын дарга өөрөө өөртөө ур чадварын нэмэгдэл олгосон, мөн нягтлан бодогч нь ээлжийн амралтын олговрыг 1.5 дахин өсгөн тооцон авсантай холбоотой нийт 4,067.3 мянган төгрөгийг зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

3.2.1 Бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагад шатахуун тослох материалд үндсэн баримтгүй зарцуулсан, жолоочийн тооцооны хуудасгүй 292,297.9 мянган төгрөгийг зарцуулсан, няравын тайлангаарх бараа материалын орлого, зарлага, эцсийн үлдэгдлийг 209,492.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, байгууллагын харилцахаас нярав орлогод аваагүй 41,443.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн баримтгүйгээр шилжүүлсэн, нийт 543,233.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн санхүүгийн тайлагналын иж бүрэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслаан зогсоох албан шаардлага өгсөн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1 Бүтэц орон тоо, дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын 2025 оны бүтэц орон тоо, төсөв батлуулаагүй, өөрийн орлогын тооцоо болон бусад харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдээгүй, санхүүгийн анхан шатны иж бүрдэл болоогүй баримтаар гүйлгээ хийсэн зэрэгт байгууллагын удирдлагын зүгээс тавих дотоод хяналт сул байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар төсөв, бүтэц орон тоог батлуулж төсвийг захиран зарцуулан байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг хуулийн хүрээнд сайжруулж, санхүүгийн анхан шатны иж бүрэн баримтаар төсвийг зарцуулах.

3.3.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь 153/ШШ2024/00263, 319/ШШ2025/000485 дугаартай шүүхийн шийдвэрээр байгууллагын нягтлан бодогчийн ажиллаагүй хугацааны цалин, НДШ, тэмдэгтийн хураамж зэрэг нийт 19,892.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18

дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвөөс төлсөн зардлыг буруутай албан тушаалтнаар төлүүлж, төсвийг хохиролгүй болгох.

3.3.3 Авлага, өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацааны авлага 2,403.0 мянган төгрөг, өглөг 2,096.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, оршин байх, иж бүрэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагуудтай хийх тооцоог харилцагч байгууллагаа бүрээр дахин тулган тооцоо нийлж, авлага, өглөгийн үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
								Залруулсан		Залруулаагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
“Шинэ Ховд Жаргалант ТҮК” (Эрч хүч тохижилт үйлчилгээ ОНӨХХК)	Аймгийн ИТХ-ын 2025.07.18-ний өдрийн А/54 тоот тогтоолоор Бичигт багийн халуун усны барилгыг Шим ус ОНӨААТҮГ-аас шилжүүлэн авсныг үндсэн хөрөнгөнд тусгаагүй	1	110,750.9			1	110,750.9	1	110,750.9		
ДҮН		1	110,750.9			1	110,750.9	1	110,750.9		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
“Шинэ Ховд Жаргалант ТҮК” (Эрч хүч тохижилт үйлчилгээ ОНӨХХК)	2025 онд тус байгууллагын дарга өөрөө өөртөө ур чадварын нэмэгдэл олгосон, мөн нягтлан бодогч нь ээлжийн амралтын олговрыг 1.5 дахин өсгөн тооцон авсан	1	4,067.3	1	4,067.3				
	Тус байгууллагад шатахуун тослох материалд үндсэн баримтгүй зарцуулсан, жолоочийн тооцооны хуудасгүй 292,297.9 мянган төгрөгийг зарцуулсан, няравын тайлангаарх бараа материалын орлого, зарлага, эцсийн үлдэгдлийг 209,492.6 мянган төгрөгийн зөрүүтэй зөрүүтэй тайлагнасан, байгууллагын харилцахаас нярав орлогод аваагүй 41,443.0 мянган төгрөгийг үндсэн баримтгүйгээр шилжүүлсэн	1	543,233.5			1	543,233.5		

“Шинэ Ховд Жаргалант ТҮК” (Эрч хүч тохижилт үйлчилгээ ОНӨХХК)-ны
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2025 онд 153/ШШ2024/00263, 319/ШШ2025/000485 дугаартай шүүхийн шийдвэрээр байгууллагын нягтлан бодогчийн ажиллаагүй хугацааны цалин, НДШ, тэмдэгтийн хураамжийг төсвөөс төлсөн	1	19,892.0					1	19,892.0
2025 оны өглөг 2.0 сая төгрөг, авлага 2.4 сая төгрөгөөр илүү тайлагнасан	1	4,499.6					1	4,499.6
Тус байгууллагын 2025 оны бүтэц орон тоо, төсөв батлуулаагүй, өөрийн орлогын тооцоо болон бусад харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдээгүй	1	-					1	-
ДҮН	5	571,692.4	1	4,067.3	1	543,233.5	3	24,391.6

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1					1	
	НИЙТ	1	1					1	